



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/196

Чингис хот

Шалгалтын комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5-ын "а", Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.16, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 112 дугаар тушаалаар батлагдсан "Ерөнхий боловсролын сургууль төгсөгчдөд боловсролын баримт бичиг олгох журам"-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2017-2018 оны хичээлийн жилийн ерөнхий болрвсролын сургууль төгсөгчдөд боловсролын баримт бичиг олгох ажилд хяналт тавих үүрэг бүхий шалгалтын комиссыг дор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дарга :	С.Мөнхцэцэг	-Боловсрол, соёл, урлагийн газрын дарга
Гишүүд:	Д.Өнөрцэцэг	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн
	Я.Батбилэгт	-Боловсрол, соёл, урлагийн газрын ахлах мэргэжилтэн
	П.Ариунбаатар	-Боловсрол, соёл, урлагийн газрын мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Э.Болормаа	-Боловсрол, соёл, урлагийн газрын ахлах мэргэжилтэн

2. Баримт бичиг олгох ажилд зохих журмын дагуу хяналт тавьж ажиллахыг ажлын хэсэг /С.Мөнхцэцэг/-т даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА

